



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 01/68

Цагаантолгой

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд залуучуудын эрүүл мэндийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй “Дентал Трэк” төслийн хүрээнд шүдний анхан шатны үзлэг, оношлогоо, эмчилгээ, сургалтын ажлыг суманд зохион байгуулах, бэлтгэлийг хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч- Б.Мөнх-Эрдэнэ- (сумын Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга- Б.Батсүрэн- (Ерөнхий боловсролын сургуулийн багш)
Гишүүдэд- Э.Очгэрэл- (Эрүүл мэндийн төвийн дарга)
Д.Өлзийбадрах- (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)
Л.Хүрэлмаа- (1-р цэцэрлэгийн эрхлэгч)

2. Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангаж, ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийг тодорхой хуваарилж хариуцуулах, бэлтгэл ажлыг сайтар хангах, төслийн ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

С.ШИЖИРБААТАР

С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: *У. Аюушаргал*
Хянасан: *С. Шиндэрбаяр*
Хувь: *2.*
2022.05.19